



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 200

Улаанбаатар хот


“Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын
бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур
үзүүлэлт тогтоох журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.12, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭГЧ,
ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД



001177

Санхүүгийн зохицуулах хорооны
2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн
200 дугаар тогтоолын хавсралт

ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН АКТИВЫН БҮРЭЛДЭХҮҮН, ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОГТООХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар хамтын хөрөнгө оруулалтын сангийн активт байгаа хөрөнгийн багцын бүрэлдэхүүнд тавигдах нийтлэг болон тусгай шаардлага, сангийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтооно.

1.2. Хамтын хөрөнгө оруулалтын сан /цаашид “Сан” гэх/-гийн хөрөнгийг итгэмжлэн удирдах гэрээний дагуу удирдаж буй хөрөнгө оруулалтын менежментийн компани /цаашид “ХОМК” гэх/ нь энэхүү журмаар тогтоосон сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг байнга хангаж ажиллана.

1.3. Энэхүү журмын 1.2, 10.1 дэх хэсгүүдийг хангаж ажиллаагүй нь тухайн ХОМК-ийн тусгай зөвшөөрлийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.13-д зааснаар хүчингүй болгох, сангийн удирдлагыг өөр ХОМК-д шилжүүлэх үндэслэл болно.

1.4. Энэхүү журмын 1.2 дахь хэсгийг зөрчсөнөөс сангийн нэгж эрх эзэмшигч хөрөнгө оруулагчдад учирсан хохирлыг ХОМК өөрийн хөрөнгөөр барагдуулах үүрэг хүлээх бөгөөд энэ талаар сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах гэрээнд заавал тусгасан байна.

1.5. ХОМК нь сангийн активын бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.3-т заасны дагуу тус журмын нийтлэг шаардлагад нийцүүлэн бодлогын баримт бичигт тодорхой тусгана.

1.6. Хамтын хөрөнгө оруулалтын санг хөрөнгө оруулалтын зорилгоос хамааруулан хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт дараах байдлаар ангилж болно:

- 1.6.1. Өмчлөлийн үнэт цаасны сан;
- 1.6.2. Тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн сан;
- 1.6.3. Тэнцвэрийн сан;
- 1.6.4. Мөнгөний зах зээлийн сан;
- 1.6.5. Индексийн сан.

1.7. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

1.7.1. “Өмчлөлийн үнэт цаасны сан” гэж зөвхөн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаанд хөрөнгө оруулахаар хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан санг;

1.7.2. “Өсөлтийн хувьцааны сан” гэж ихэнх тохиолдолд ногдол ашиг хуваарилдаггүй боловч өсч буй компанийн хувьцааны санг;

1.7.3. “Орлогын хувьцааны сан” гэж өндөр хэмжээний ногдол ашиг хуваарилдаг компаниудын хувьцааны санг;

1.7.4. “Үнэ өсөх хувьцааны сан” гэж санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдтэй нь харьцуулахад харьцангуй хямд үнээр арилжаалагдаж буй хувьцааны санг;

1.7.5. “Зах зээлийн үнэлгээний сан” гэж зах зээлийн үнэлгээ нь өндөр, дунд, болон бага компанийн хувьцааны санг;

1.7.6. “Нийтлэг сан” гэж тус журмын 1.7.2-1.7.5 хүртэлх бүх төрлийн хувьцаанд хөрөнгө оруулдаг санг;

1.7.7. “Тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн сан” гэж Засгийн газрын өрийн хэрэгсэл, зэрэглэл өндөртэй нээлттэй хувьцаат компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг тогтмол хүүтэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахаар хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан санг;

1.7.8. “Тэнцвэрийн сан” гэж өмчлөлийн болон тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлийн аль алинд нь хөрөнгө оруулахаар хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан санг;

1.7.9. “Мөнгөний зах зээлийн сан” гэж нэг жил хүртэл хугацаатай тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахаар хөрөнгө оруулалтын бодлогодоо заасан санг;

1.7.10. “Индексийн сан” гэж индексийн гүйцэтгэлд үндэслэн хөрөнгө оруулалт хийхээр хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт тусгасан санг.

Хоёр. Өмчлөлийн үнэт цаасны сангийн активын бүрэлдэхүүнд тавигдах шаардлага

2.1. Өмчлөлийн үнэт цаасны санг дараах байдлаар ангилж болно:

2.1.1. Өсөлтийн хувьцааны сан;

2.1.2. Орлогын хувьцааны сан;

2.1.3. Үнэ өсөх хувьцааны сан;

2.1.4. Зах зээлийн үнэлгээний сан;

2.1.5. Нийтлэг сан.

2.2. Сангийн эрсдэлийг багасгахын тулд өмчлөлийн хэрэгсэлд оруулах хөрөнгийн нийт хэмжээ нь сангийн нийт активын 70 хувиас хэтрэхгүй байх ба үлдэх 30-аас доошгүй хувийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.5, 26.1.8-д заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэлд оруулна.

2.3. Эдийн засгийн зөвхөн нэг салбарт хөрөнгө оруулахаар хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт тусгасан тусгай зориулалтын сан, Хорооноос тусгайлан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд сангийн хөрөнгөөр нэг салбарт хөрөнгө оруулалт хийх дээд хязгаар нь сангийн нийт активын 25 хувиас хэтрэхгүй байна.

2.4. Өмчлөлийн сан нь нэг үнэт цаас гаргагчийн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийтэд санал болгон гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг дангаар эзэмшихийг, түүнд сангийн нийт активын 5-аас дээш хувиар хөрөнгө оруулахыг тус тус хориглоно.

2.5. ХОМК нь өмчлөлийн санг энэ журмын 2.1-д заасан ангиллын дагуу тодорхойлж бодлогын баримт бичигт тодорхой тусгана.

Гурав. Тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн сангийн

активын бүрэлдэхүүнд тавигдах шаардлага

3.1. Тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн сангийн активын бүрэлдэхүүнд дараах шаардлагыг тавина:

3.1.1. Зөвхөн нийтэд арилжаалагддаг өрийн хэрэгслүүд болох Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл, зохицуулалттай зах зээлд чөлөөтэй арилжаалагдаж буй компанийн өрийн хэрэгсэл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хөрөнгө оруулах;

3.1.2. Сангийн худалдан авч болох өрийн хэрэгслийн хүчинтэй байх хугацаа нь сангийн үйл ажиллагаа явуулах үлдсэн хугацаанаас богино байх;

3.1.3. Компанийн өрийн хэрэгсэл болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухайд дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

3.1.3.а. зөвхөн компанийн өр дээр суурилсан үнэт цааснаас бүрдсэн байх;

3.1.3.б. компанийн өрийн хэрэгсэл нь санхүүжих чадавхийн зэрэглэл тогтоох байгууллагын дундаас дээш № ангилалд хамаарах;

3.1.4. Нэг үнэт цаас гаргагчийн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийтэд санал болгон гаргасан тодорхой нэг өрийн хэрэгслийн 10 хувиас дээш эзэмшихгүй байх;

3.1.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд оруулсан нийт хөрөнгө нь сангийн нийт активын 15 хувиас илүүгүй байх;

3.1.6. Энэхүү журмын 3.1.4 болон 3.1.5-д заасан хязгаарлалтыг хангахын зэрэгцээ арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нэг үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргасан нийт өрийн хэрэгслийн 10 хувиас дээш эзэмшихгүй, түүнд оруулсан хөрөнгө нь сангийн нийт активын 15 хувиас хэтрэхгүй байх;

3.1.7. Сангийн нийт активын 85 хувиас багагүй хувийг тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлд оруулах;

3.1.8. Энэхүү журмын 3.1.6-д заасан хязгаарлалт нь Засгийн газрын өрийн хэрэгсэлд хамаарахгүй.

Дөрөв. Тэнцвэрийн сангийн активын бүрэлдэхүүнд тавигдах шаардлага

4.1. Тэнцвэрийн сангийн активын бүрэлдэхүүнд дараах шаардлага тавина:

4.1.1. Зөвхөн нийтэд арилжаалагдаж буй хувьцаа болон Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл, зохицуулалттай зах зээлд арилжаалагдаж буй компанийн өрийн хэрэгсэл, Хороонд бүртгэлтэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хөрөнгө оруулна.

4.1.2. Өмчлөлийн хэрэгсэл болох хувьцаанд оруулах хөрөнгийн дээд хязгаар нь сангийн нийт активын 60 хувиас хэтрэхгүй байх;

4.1.3. Тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлд оруулах хөрөнгийн дээд хязгаар нь сангийн нийт активын 60 хувиас хэтрэхгүй байх;

4.1.4. Эдийн засгийн нэг салбарт оруулсан хөрөнгө нь сангийн нийт активын 25 хувиас хэтрэхгүй байх;

4.1.5. Нэг үнэт цаас гаргагчийн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны /хувьцаа болон өрийн хэрэгсэл/ 10 хувиас дээш эзэмшихгүй байх;

4.1.6. Нэг үнэт цаас гаргагчийн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийтэд санал болгон гаргасан үнэт цаасанд /хувьцаа болон өрийн хэрэгсэл/ оруулсан хөрөнгө сангийн нийт активын 5 хувиас хэтрэхгүй;

4.1.7. Энэ журмын 4.1.5 болон 4.1.6-д заасан хязгаарлалт нь Засгийн газрын өрийн хэрэгсэлд хамаарахгүй.

4.1.8. Өмчлөлийн үнэт цаасны сан болон тогтмол орлоготой санхүүгийн хэрэгслийн сангуудын хувьд тогтоосон энэхүү журмын 2.3 болон 3.1.6-д заасан хязгаарлалтууд нь тэнцвэрийн сангийн хувьд нэгэн адил хамаарна.

Тав. Мөнгөний зах зээлийн сангийн активын бүрэлдэхүүнд тавигдах шаардлага

5.1. Мөнгөний зах зээлийн сан нь нэг жил хүртэл хугацаатай дараах тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахаар хөрөнгө оруулалтын бодлогодоо тусгана.

5.1.1. Засгийн газрын болон аймаг, нийслэлийн Засаг даргын богино хугацаатай өрийн хэрэгсэл;

5.1.2. Зохицуулалттай зах зээлд нээлттэй арилжаалагддаг компанийн богино хугацаатай өрийн хэрэгсэл;

5.1.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу гаргасан богино хугацаатай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас.

5.2. Мөнгөний зах зээлийн санд энэ журмын 5.1-д зааснаас гадна дараах шаардлага тавигдана. Үүнд:

5.2.1. Зөвхөн нээлттэй хамтын сангийн хэлбэртэй зохион байгуулагдсан байх;

5.2.2. Сангийн худалдан авч болох өрийн хэрэгсэл нь хугацааны хувьд дараах нэмэлт шаардлагын аль нэгийг хангасан байна.

5.2.2.а. Анх гаргах үед тогтоосон хугацаа нь 397 өдөр буюу 13 сараас илүүгүй байх;

5.2.2.б. Сан худалдан авах үед үлдэгдэл хугацаа нь 397 өдөр буюу 13 сараас илүүгүй байх.

5.2.3. Компанийн өрийн хэрэгсэл болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухайд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой:

5.2.3.а. Зөвхөн компанийн өр дээр суурилсан үнэт цааснаас бүрдсэн байх;

5.2.3.б. Компанийн өрийн хэрэгсэл нь санхүүжих чадавхийн зэрэглэл тогтоох байгууллагын зөвхөн дээд ангилалд хамаарах.

5.3. Мөнгөний зах зээлийн сан нь төвлөрлийн талаар дараах шаардлагыг хангасан байна.

5.3.1. Сангийн нийт хөрөнгийн 5%-иас илүүгүйг нэг үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргасан мөнгөний зах зээлийн хэрэгсэлд оруулж болно.

5.3.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд оруулсан нийт хөрөнгө нь сангийн нийт хөрөнгийн 10%-иас хэтрэхгүй. Энэхүү хязгаарлалт нь Засгийн газар болон орон

нутгийн засаг захиргааны гаргасан эсхүл баталгаа олгосон үнэт цаас болон Төв банкны үнэт цаасанд хамаарахгүй.

5.4. Сан нь үйл ажиллагаа явуулах бүх хугацааны туршид дор дурьдсан багцын шаардлагыг хангаж байна:

5.4.1. багцад багтаж буй санхүүгийн хэрэгсэлийн жигнэсэн дундаж хугацаа /ЖДХ/ нь 120 өдрөөс илүүгүй байх.

5.4.2. Жигнэсэн дундаж хугацаа /ЖДХ/ гэж сангийн багцад байгаа өрийн хэрэгсэл тус бүрийн дуусах хугацаа эсхүл сангийн эзэмшилд байх хугацааг сангийн багцад байгаа тухайн хөрөнгийн хувийн жингээр жигнэж дундаж хугацаагаар тооцно.

Зургаа. Индексийн сангийн активын бүрэлдэхүүнд тавигдах шаардлага

6.1. Индексийн сан нь зөвхөн тухайн индексийн багцад багтаж буй үнэт цаасанд хөрөнгө оруулна.

6.2. Индексийн сангийн багц бүрдэлт, төвлөрөл болон активын бүрэлдүүнд шалгуур үзүүлэлт тогтоохгүй.

6.3. Нээлттэй индексийн санд энэ журмын 7 дугаар зүйлд заасан хөрвөх чадварын шалгуур үзүүлэлт хамаарна.

Долоо. Хөрөнгө оруулалтын сангийн хөрвөх чадварын шалгуур үзүүлэлтийг тогтоох

7.1. Нээлттэй сангийн нийт активын 10-аас доошгүй хувийг бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах дараах хөрөнгөнд оруулж болно:

7.1.1. банкны хадгаламж;

7.1.1.а. Банкны хадгаламжийг хүссэн цагтаа буюу шаардсан тухай бүр эргүүлэн татах боломжтой байх бөгөөд хадгаламжийн дээд хугацаа нь 12 сараас илүүгүй байх.

7.1.2. Засгийн газрын богино хугацаатай үнэт цаас.

7.2. Сангийн нийт активын 10-аас дээш хувийг хөрвөх чадвар муутай хэрэгсэлд хөрөнгө оруулахыг хориглоно.

7.3. Нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй хаалттай сангийн хувьд бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн шаардлага тавигдахгүй.

Найм. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлага

8.1. ХОМК нь өөрийн үүсгэн байгуулсан сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувиас доошгүй хэмжээгээр хөрөнгө оруулалт хийнэ.

8.2. Сангийн цэвэр активын (хөрөнгийн) үнэлгээний хэмжээнд үндэслэн ХОМК-иас оруулсан хөрөнгийн хэмжээг улирал бүр хянаж, энэхүү журмын 7.1-т заасан 5 хувийн хязгаараас буурсан тохиолдолд нэмэлт хөрөнгө оруулалт хийнэ.

8.3. ХОМК нь оруулсан хөрөнгөдөө тохирох хэмжээний нэгж эрхийг эзэмшинэ.

8.4. ХОМК нь оруулсан хөрөнгөө зөвхөн сангийн үйл ажиллагааны хугацаа дуусгавар болж, бүх өр төлбөрийг барагдуулан, бусад нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийг хуваарилан өгсний дараа эргүүлэн авна.

Ес. Хамтын хөрөнгө оруулалтын санд тавигдах зээлийн хөрөнгө /санхүүгийн хөшүүрэг/-ийн хязгаарлалт

9.1. Сан нь хөрөнгө оруулалт хийх зорилгоор санхүүгийн хөшүүрэг ашиглахыг хориглоно.

9.2. Онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд сан нь Хорооны зөвшөөрлөөр цэвэр активын (хөрөнгийн) 10 хувиас хэтрэхгүй хэмжээний зээл авч болно.

9.3. “Онцгой нөхцөл байдал” гэдэг дараах нөхцөл байдал үүссэнийг хамааруулна:

9.3.1. нэгж эрхээ эргүүлэн худалдах ихээхэн хэмжээний захиалга нэг дор ирсний улмаас хэдийгээр хөрвөх чадварын тогтоосон харьцааг хангаж байгаа хэдий ч мөнгөн хөрөнгө хүрэлцэхгүй болсон;

9.3.2. нэгж эрхээ эргүүлэн худалдан авах шаардлагыг хэрэгжүүлж байгаа үед тухайн үйл ажиллагааны арилжааг зогсоосон.

9.4. Энэхүү журмын 8.2-т заасны дагуу авсан зээлийн хугацаа 6 сараас хэтрэхгүй байх бөгөөд зөвхөн нэгж эрхээ эргүүлэн худалдан авахад зориулагдана.

Арав. Активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийг тайлагнах

10.1. Нээлттэй сан нь дүрэмдээ сангийн нэгж эрхийг ямар хугацаанд (өдөр бүр, долоо хоног бүр, сар бүр) худалдан авахаар зааснаас шалтгаалан нэгж эрхийн болон цэвэр активын (хөрөнгийн) үнэлгээний тайланг мөн хугацаанд гаргаж Хороонд хүргүүлнэ.

10.2. Хаалттай сан нь энэхүү журмын 10.1-д заасан тайланг улирал бүр гаргаж Хороонд хүргүүлнэ.

10.3. Энэхүү журмын 10.1 болон 10.2-т заасан тайланд үндэслэн энэ журмаар тогтоосон сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд сангийн дотоод хяналтын журмаар тогтоосон эрх бүхий этгээд хяналт тавина.

10.4. Энэхүү журмын 10.1 болон 10.2-т заасан тайланд үндэслэн тус журмаар тогтоосон сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд Хорооноос хяналт тавина.

10.5. Сангийн активын бүрэлдэхүүн, зохистой харьцааны үзүүлэлтүүд нь энэхүү журмаар тогтоосон шаардлагад нийцээгүй байвал нийцүүлэх талаар ХОМК-д Хорооноос хугацаатай үүрэг даалгавар өгч, үүрэг даалгаврын хувийг тухайн сангийн кастодиан болон сангийн төлөөлөн удирдах зөвлөлд тус тус хүргүүлнэ.

Арван нэг. Хариуцлага

11.1. Энэхүү журамд заасан хугацаанд Хорооноос тавьсан шаардлагыг хэрэгжүүлээгүй бол сангийн төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэл хүргүүлж, дараах арга хэмжээг дэс дараатайгаар авна:

11.1.1. ХОМК-д эсхүл тухайн санг удирдахаар томилогдсон тухайн сангийн менежерт захиргааны хариуцлага хүлээлгэх;

11.1.2. Сангийн нэгж эрх гаргах, эргүүлэн худалдан авах үйл ажиллагааг түдгэлзүүлэх;

11.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Хорооноос баталсан холбогдох дүрэм, журамд заасан бусад арга хэмжээг хэрэгжүүлнэ.